



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 118

Шивээговь сум

Золбин нохой, муур устгалын  
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 58 дугаар “Журам батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Сумын хэмжээнд золбин нохой, муур устгалын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 07 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Золбин нохой, муур устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Л.Чанцалмаа  
(1 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд:

С.Отгонбаатар  
(2 дугаар багийн Засаг дарга)  
Д.Амартүвшин  
(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)  
Г.Дашдэлэг  
(Мал эмнэлгийн тасгийн)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх  
(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

3.Золбин нохой, муур устгалын ажилд зарцуулагдах 1,125,000 (нэг сая нэг зуун хорин таван мянга) төгрөгийг “Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал”-аас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

4.Ажлыг чанартай зохион байгуулж, тайланг гарган танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (Л.Чанцалмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНЖАРГАЛ